213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		1404840.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>460000.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	460000.00
225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		460000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	0.00	80186398.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	0.00	80186398.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		33144500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		23520949.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		23520949.00

## Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Бугат сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Х.Ууганбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 09-өөс 2021 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Тэргүүлэх аудитор Д.Анхбаяр хоёр дахь шатны, аудитын менежер Ж.Энхцоодол, ахлах аудитор П.Содном нар анхан шатны хяналтыг тус тус хэрэгжүүлэн, аудитор А.Сувдаа хариуцан гүйцэтгэв.

Бугат сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 1/53 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Бугат сумын Засаг даргын 2020 оны үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Монгол Улсын Их Хурлын 2016 оны 69 дүгээр тогтоол, 2017 оны 29 дүгээр тогтоол, 2014 оны 147 дугаар тогтоол, 2018 оны 382 дугаар тогтоол, 2015 оны 230 дугаар тогтоолуудыг хэрэгжүүлж сумын ИТХ-ын хуралдаанаар батлуулсан төлөвлөлтийн дагуу төсвийн орлогыг нэмэгдүүлэх, төлөвлөгөөг биелүүлэх, төсвийн зардлыг хэмнэх, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх, төсвийн сахилга хариуцлагыг сайжруулах” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- ✓ ЕБС-ийн сургууль хүүхдийн таатай сурч боловсрох болон амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэх 50 хүүхдийн дотуур байртай болох
- ✓ Суманд гадна, дотноос айлчин ирэх, сумын иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор сумын төвийн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэн шинэчлэх
- ✓ СӨБ-ын сурагчдын сурч хөгжих таатай орчин бүрдүүлэх, үйл ажиллагааг дэмжиж зорилгоор тус цэцэрлэгт өргөтгөл хийх
- ✓ ЭМТ-ийн ард иргэдэд үйлчлэх таатай орчин бүрдүүлэх, ариутгал халдваргүйжүүлэлтийг сайжруулах зорилгоор автоклав, Түргэн шуурхай дуудлагын дагуу цаг алдалгүй иргэдэд хүргэх зорилгоор УАЗ Пургон маркийн суудлын авто машинтай болох, иргэдийг шинжилгээ үйлчилгээнд түргэн хамруулах зорилгоор лабораторийн Хяналтын мониторинг шинжилгээний аппараттай болгох

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Бугат сумын Засаг дарга нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан

төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тайланд 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

### 3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 2455.9 сая төгрөгийн 2 хувь буюу 49.1 сая төгрөгөөр тогтоов. Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

### 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 120.6 сая, эцсийн үлдэгдэл 192.4 сая төгрөг болж, 71.8 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт (+), Бууралт (-)</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>
Төрийн сангийн харилцах	90.84	164.71	73.87	100%
Арилжааны банкин дахь харилцах	0.10	0.00	-0.10	0%
<b>Дүн</b>	<b>90.94</b>	<b>164.71</b>	<b>73.77</b>	<b>100%</b>
<b><i>Үүнээс байгууллагын төрлөөр</i></b>				
Төсөвт байгууллага	36.15	112.91	76.76	68.6%
Төсөл/сан			0.00	0.0%
Төрийн сан	54.69	51.80	-2.89	31.4%
ТӨҮГ болон ОНӨҮГ	0.10		-0.10	0.0%
<b>Дүн</b>	<b>90.9</b>	<b>164.7</b>	<b>73.8</b>	<b>100%</b>

*Эх сурвалж: Бугат сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа БХС-гийн 17.6 сая, СХС-гийн 58.1 сая, ОНӨО 61.7 сая, ОНХС-гийн 53.1 сая нийт 192.3 сая төгрөг буюу төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд, ЗДТГ-ын 0.8 сая, ИТХ-ын 0.3 сая нийт 1.1 сая төгрөг арилжааны банкин дахь харилцах дансны үлдэгдлээр байна. Энэ нь оны сүүлд арилжааны банкны харилцах дансаар дамжуулан худалдан авалт хийх үед зарцуулах эрх хаагдан өглөг үүсэн, харилцах дансны үлдэгдлээр тайлагнажээ.

Замд яваа мөнгөн хөрөнгө, хадгаламж дансанд мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

#### 3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансанд үлдэгдэлгүй байна

### 3.5.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 260.3 сая, эцсийн үлдэгдэл 250.5 сая төгрөг болж, 9.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.61	6.42	5.806	3%
Зээлийн хүүгийн авлага	6.00	2.99	-3.009	1%
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/			0	0%
Байгууллагаас авах авлага	15.85	21.94	6.09	9%
Хувь хүнээс авах авлага	237.86	219.1	-18.761	87%
<b>Дүн</b>	<b>260.32</b>	<b>250.45</b>	<b>-9.87</b>	<b>100%</b>
Үүнээс байгууллагын төрлөөр				
Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан	10.38	14.98	4.603	6.0%
Засаг даргын тамгын газар	1.22	6.86	5.643	2.7%
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1.42	1.42	-0.003	0.6%
Соёлын төв	0.61	0.94	0.326	0.4%
Сум хөгжүүлэх сан	209.85	184.98	-24.867	73.9%
Сургууль	2.67	5.06	2.387	2.0%
Хүн эмнэлэг	8.76	10.21	1.4545	4.1%
Цэцэрлэг	0.83	3.92	3.086	1.6%
Эргэлтийн эмийн сан	2.50	0.00	-2.5	0.0%
Орон нутгийн ерөнхий орлого	2.08	2.08	0	0.8%
Орон нутгийн хөгжлийн сан	20.00	20.00	0	8.0%
Элгэн бугат			0	0.0%
<b>Дүн</b>	<b>260.32</b>	<b>250.45</b>	<b>-9.87</b>	<b>100%</b>

Эх сурвалж: Бугат сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 17.5 сая төгрөгийн авлага нэмэгдсэн бөгөөд олон жилийн насжилттай 112.3 сая төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- СХС-гаас олгож буй зээл үлдэгдэл 184.9 сая төгрөгийн 93.2 сая төгрөгийн зээл нь 2011-2018 онд олгосон зээл, ЖДҮДС-гийн үлдэгдэл 15.0 сая төгрөгийн 10.3 сая төгрөгийн 2012-2016 оны зээл, ЭМТ-ийн 8.8 сая төгрөгийн 2013 оны насжилттай авлага байна.

#### Аудитын илрүүлэлт:

- Хүүхдийн тоглоом худалдах, худалдан авахдаа гэрээний 1.3 дахь заалтыг хэрэгжүүлээгүй бараа бүтээгдэхүүнээ хугацаандаа аваагүйгээс, төсвийн шууд захирагч төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлээгүй авлага үүсгэж, харилцагч байгууллагатай тооцоо нийлсэн акт үйлдээгүй байна. Тухайлбал: Сургуулийн өмнөх боловсрол 3.0 сая төгрөг.
- Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх." гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна. Тухайлбал: ЗДТГ 6.9 сая, СӨБ 5.1 сая, СХС-гийн 93.2 сая, ЖДҮДС-гийн 10.3 сая, ЭМТ-ийн 8.8 сая төгрөг

### 3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны үлдэгдэлгүй байна

### 3.5.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтын үлдэгдэлгүй байна.

### 3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 259.6 сая, эцсийн үлдэгдэл 288.9 сая төгрөг болж, 29.4 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эдлэх хувь
Эм боох материал	16.42	20.57	4.15	7.12%
Бичиг хэргийн материал	2.18	3.96	1.78	1.37%
Аж ахуйн материал	196.45	226.10	29.65	78.24%
Сэлбэг хэрэгсэл	2.42	3.06	0.64	1.06%
Түлш шатах тослох материал	9.01	2.90	-6.11	1.00%
Хүнсний материал	7.6	4.91	-2.69	1.70%
Бусад хангамжийн материал	1.02	2.96	1.94	1.02%
Мал амьтад	24.52	24.52	0.00	8.49%
<b>Дүн</b>	<b>259.62</b>	<b>288.98</b>	<b>29.36</b>	<b>100%</b>
<b>Үүнээс байгууллагын төрлөөр</b>				
Засаг даргын тамгын газар	65.88	74.31	8.43	25.72%
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1.11	2.23	1.12	0.77%
Соёлын төв	14.49	15.57	1.09	5.39%
Сургууль	94.97	107.28	12.32	37.13%
Хүн эмнэлэг	46.28	58.44	12.16	20.22%
Цэцэрлэг	29.14	31.14	2.00	10.78%
Эмийн эргэлтийн сан	7.76	0.00	-7.76	0.00%
<b>Дүн</b>	<b>259.62</b>	<b>288.98</b>	<b>29.36</b>	<b>100%</b>

*Эх сурвалж: Бугат сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 172.9 сая, хандиваар 10.6 сая, бусад эх үүсвэрээс 1.8 сая төгрөгөөр нэмэгдэж, зарцуулсан 144.8 сая, шилжүүлсэн 0.3 сая, акталсан 10.9 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хассан байна.

Бараа материалын тайлангийн үлдэгдэлд тайлант оны эцэст 264.4 сая төгрөгийн эм боох материал, бичиг хэрэг, аж ахуйн материал, сэлбэг хэрэгсэл, түлш шатах тослох материал, хүнсний материал, бусад хангамжийн материалыг төсвийн хэмнэлтийг улс, орон нутгийн буцаан төсөвт төвлөрүүлэхгүй шалтгаанаар нөөцөлсөн байна.

#### Аудитын илрүүлэлт:

-  Бараа материалын ангиллыг шууд зардлаар буюу орлого зарлагаар бүртгээгүй, орлого дутуу бүртгэсэн байна. Тухайлбал: ЭМТ 8.1 сая төгрөг
-  Жилийн эцсийн тооллогоорх бараа материалын үлдэгдэл санхүүгийн тайланд илэрхийлэгдсэн дүнг зөрүүтэй, тооллогын анхан шатны баримтын хөтлөлт дутуу. Тухайлбал: ЭМТ 23.9 сая төгрөг

### 3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 2420.1 сая, эцсийн үлдэгдэл 4494.7 сая төгрөг болж, 2074.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Барилга байгууламж, орон сууц	1,918.46	4,015.99	2,097.53	89%
Хуримтлагдсан элэгдэл	-209.97	-293.33	-83.36	-7%
Авто-тээврийн хэрэгсэл	257.17	302.37	45.20	7%
Хуримтлагдсан элэгдэл	-161.78	-183.53	-21.75	-4%
Машин тоног төхөөрөмж/компьютер/	432.31	335.21	-97.10	7%
Хуримтлагдсан элэгдэл	-326.29	-172.41	153.88	-4%
Тавилга, аж ахуйн эд хогшил	163.31	120.16	-43.15	3%
Хуримтлагдсан элэгдэл	-118.38	-61.20	57.18	-1%
Түүх соёл, музейн дурсгалт зүйл	16.28	16.28	0.00	0%
Бусад үндсэн хөрөнгө	319.19	313.42	-5.77	7%
Хуримтлагдсан элэгдэл	-116.36	-147.26	-30.90	-3%
Ном	29.68	30.26	0.59	1%
Программ хангамж	6.09	7.60	1.51	0%
Хуримтлагдсан элэгдэл	-4.66	-3.93	0.73	0%
Бусад биет бус хөрөнгө	215.11	215.11	0.00	5%
Хуримтлагдсан элэгдэл			0.00	0%
<b>Дүн</b>	<b>2,420.14</b>	<b>4,494.73</b>	<b>2,074.60</b>	<b>100%</b>
Засаг даргын тамгын газар	1,160.25	1,094.04	-66.21	24.3%
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	0.56	5.39	4.83	0.1%
Соёлын төв	42.54	29.49	-13.05	0.7%
Сум хөгжүүлэх сан	9.86	6.96		
Сургууль	551.78	2,651.12	2,099.33	59.0%
Хүн эмнэлэг	618.40	665.09	46.69	14.8%
Цэцэрлэг	36.47	42.66	6.19	0.9%
Эмийн эргэлтийн сан	0.28		-0.28	0.0%
<b>Дүн</b>	<b>2,420.14</b>	<b>4,494.73</b>	<b>2,077.50</b>	<b>100%</b>

сурвалж: Бугат сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 17.9 сая, хандиваар авсан 68.4 сая, элэгдлээ бүрэн нөхсөн хөрөнгийг үнийг дахин шинэчилсэн болон бусад 2174.9 сая төгрөгөөр нэмэгдсэн, акталсан 87.9 сая, элэгдлээ бүрэн нөхсөн хөрөнгийг үнийг дахин шинэчилсэн болон бусад 174.6 сая төгрөгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

ЗДТГ нь жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд зааврын дагуу үнэн зөв, чанартай явуулж тооллогын явц үр дүнг комиссын хурлаар хэлэлцэж, тооллогын бүртгэлийг 2 хувь үйлдэж байгууллагын удирдлагад танилцуулан батлуулж, санхүүгийн албанд хүргүүлэх үүрэгтэй байдаг ч баримтын бүрдэл, тооцоолол дутуу байна.

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 21.9 сая, эцсийн үлдэгдэл 15.9 сая төгрөг болж, 7.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь	
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>					
Ажилчидтай холбогдсон өглөг	7.77	0.05	-7.72	0.3%	
Бараа үйлчилгээний зардлын өглөг	2.16	10.831	8.68	67.8%	
Байгууллагад төлөх өглөг	11.66	5.07	-6.59	31.7%	
Хувь хүмүүст төлөх өглөг	0.02	0.02	0.00	0.1%	
Татварын өглөг /ТӨҮГ/	0.30		-0.30	0.0%	
<b>Дүн</b>	<b>21.90</b>	<b>15.98</b>	<b>-5.93</b>	<b>100.0%</b>	
Засаг даргын тамгын газар	0.31	1.49	1.17	9.3%	
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	0.02	0.02	0.00	0.2%	
Соёлын төв	0.03	4.48	4.45	28.1%	
Сум хөгжүүлэх сан	1.12	1.17	0.04	7.3%	
Хүн эмнэлэг	0.10	0.10	0.00	0.6%	
Сургууль	2.73	0.28	-2.45	1.8%	
Цэцэрлэг		6.02	6.02	37.7%	
Эмийн эргэлтийн сан	15.16		-15.16	0.0%	
Орон нутгийн хөгжлийн сан	2.42	2.42	0.00	15.1%	
<b>Дүн</b>	<b>21.90</b>	<b>15.98</b>	<b>-5.93</b>	<b>100%</b>	
<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>					
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв		0	0	0.00	#DIV/0!
<b>Дүн</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>#DIV/0!</b>	

Эх сурвалж: Бугат сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд нийт 11.7 сая төгрөгийн өр төлбөр нэмэгдсэн нь Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4.2 дахь заалтыг хэрэгжүүлэн өр, авлага үүсгэхгүй байх шаардлагыг биелүүлээгүй, 15.9 сая төгрөгийн татварын өглөгийн үлдэгдэлтэй байна.

### 3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 3038.8 сая, эцсийн үлдэгдэл 5210.5 сая төгрөг болж, 2171.8 сая төгрөгөөр өссөн байна.

ХҮСНЭГТ № 6. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /САЯ ТӨГРӨГ/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,487.60	1,484.96	-2.64	28.50%
Хуримтлагдсан үр дүн	240.61	2,415.01	2,174.40	46.35%
Өмнөх үеийн үр дүн	396.16	252.26	-143.90	4.84%
Тайлант үеийн үр дүн	-155.55	2,162.75	2,318.30	41.51%
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,310.57	1,310.57	0.00	25.15%
<b>Дүн</b>	<b>3,038.78</b>	<b>5,210.54</b>	<b>2,171.76</b>	<b>1.00</b>
<b>Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан</b>				
Засаг даргын тамгын газар	667.24	667.24	0.00	12.81%
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	4.26	4.26	0.00	0.08%
Хүн эмнэлэг	380.95	380.95	0.00	7.31%
Сургууль	352.55	352.55	0.00	6.77%
Цэцэрлэг	30.74	30.74	0.00	0.59%
Соёлын төв	48.1	48.1	0.00	0.92%
Сум хөгжүүлэх сан	1.1	1.1		
Эмийн эргэлтийн сан	2.63		-2.64	0.00%
<b>Хуримтлагдсан үр дүн</b>				

Орон нутгийн ерөнхий орлого	45.11	63.79	18.69	1.22%
Орон нутгийн хөгжлийн сан	47.65	70.68	23.03	1.36%
Сум хөгжүүлэх сан	244.88	247.81	2.92	4.76%
Байгаль хамгаалах сан	14.77	17.60	2.83	0.34%
Жижиг дунд үйлдвэр	15.64	15.64	0.00	0.30%
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	-1.318	4.969	6.29	0.10%
Эмийн эргэлтийн сан	-7.194		7.19	0.00%
Тэшиг ус			0.00	0.00%
Сургууль	-156.78	1959.71	2,116.49	37.61%
Засаг даргын тамгын газар	112.11	59.58	-52.53	1.14%
Соёлын төв	-46.58	-62.67	-16.09	-1.20%
Цэцэрлэг	34.76	40.01	5.25	0.77%
Хүн эмнэлэг	-62.45	-2.131	60.32	-0.04%
<b>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</b>			0.00	0.00%
Сургууль	450.92	450.92	0.00	8.65%
Засаг даргын тамгын газар	447.68	447.68	0.00	8.59%
Эмийн эргэлтийн сан			0.00	0.00%
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	0.13	0.13	0.00	0.00%
Соёлын төв	56.09	56.09	0.00	1.08%
Цэцэрлэг	0.941	0.94	0.00	0.02%
Хүн эмнэлэг	354.82	354.82	0.00	6.81%
<b>ДҮН</b>	<b>3,038.78</b>	<b>5,210.54</b>	<b>2,171.76</b>	<b>100%</b>

Эх сурвалж: Бугат сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аймгийн ИТХ-ын 2020 оны 57 дугаар тогтоолоор “Эмийн эргэлтийн сан”-г хасагдуулах шийдвэр гарсан нь ЗГ-ын оруулсан хувь 2.6 сая, хуримтлагдсан үр дүнг 7.2 сая төгрөгөөр тус тус бууруулан бүртгэсэн байна.

Эздийн өмчийн бусад хэсэг дансны үлдэгдэлгүй байна. .

Хуримтлагдсан үр дүн 2415.0 сая төгрөг болж 2174.4 сая төгрөгөөр өссөн нь тус сумын ЕБС-ийн 2099.4 сая төгрөгийн барилга ашиглалтад орсноос шалтгаалжээ.

Бодлогын өөрчлөлт алдааны залруулга дансанд залруулга хийгээгүй байна.

### 3.5.10 Орлогын данс

Орлогын төлөвлөгөөг 413.9 сая төгрөгөөр баталж, 462.6 сая төгрөгийг бүрдүүлэн, 48.7 сая төгрөгөөр буюу 11.8 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №7 Орлогын гүйцэтгэл

/сая төгрөг/

ЭЗА	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт +, хэмнэлт -	Хувь
1	НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	101.08	158.53	57.45	156.8%
11	ТАТВАРЫН ОРЛОГО	83.08	128.21	45.13	154.3%
110	Орлогын албан татвар	24.34	40.88	16.54	167.9%
1100	Хувь хүний орлогын албан татвар	24.34	40.88	16.54	167.9%
110002	Үйл ажиллагааны орлого	8.00	8.88	0.88	111.0%
110003	Хөрөнгийн орлого	9.14	13.94	4.80	152.5%
110008	Шууд бус орлого	7.20	18.06	10.86	250.8%
113	Хөрөнгийн албан татвар	3.03	3.07	0.04	101.4%
113002	Бууны албан татвар	3.03	3.07	0.04	101.4%
118	Бусад татвар, төлбөр, хураамж	55.71	83.76	28.05	150.4%
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	12.20	14.65	2.45	120.1%

118001	Улсын тэмдэгтийн хураамж	4.20	5.34	1.14	127.2%
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	5.00	7.00	2.00	140.0%
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	3.00	2.31	-0.69	77.1%
1181	Газрын төлбөр	0.00	1.05	1.05	#DIV/0!
118101	Газрын төлбөр	0.00	1.05	1.05	#DIV/0!
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	43.51	68.06	24.55	156.4%
118201	Ойн нөөц ашигласны төлбөр	40.00	65.87	25.87	164.7%
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	1.01	0.98	-0.03	97.3%
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	2.00	1.07	-0.93	53.7%
118204	Байгалийн ургамал ашигласны төлбөр	0.50	0.13	-0.37	26.0%
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	18.00	30.31	12.31	168.4%
120	Нийтлэг татварын бус орлого	18.00	30.31	12.31	168.4%
120002	Хүүгийн орлого	5.70	11.01	5.31	193.2%
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1.50	1.70	0.20	113.3%
120009	нэр заагдаагүй	10.80	17.60	6.80	163.0%

Татварын орлого 45.1 сая буюу 53.4 хувиар, татварын бус орлого 12.3 сая буюу 68.4 хувиар тус тус давсан байна.

#### Аудитын илрүүлэлт:

✚ Тайлант хугацаанд төлөвлөгдөөгүй газрын 1.1 сая төгрөгийн орлого төвлөрсөн, төлөвлөгдсөн орлогын 10 нэр төрлийн орлого давсан нь хувиараа мод бэлтгэн борлуулдаг иргэдтэй татварын тооцоо хийсэн, “Эрдэнэс таван толгой” ХК-ийн хувьцаанаас, хадгаламж нэмэгдсэн, урьд оны бууны албан татварыг төлсөн, Орхон аймагт улсын чанартай авто зам баригдаж Бугат сумын нутгаас хайрга шинээр олборлосон, төлөвлөсөн модны метр куб-ээс давуулж олгосон, мөн төлбөрийн хувь хэмжээ өссөн зэргээс хамаарч орлого давсан байна. Хэдийгээр орлого нийт дүнгээр давсан ч нэр төрлөөр авч үзвэл хог хаягдлын үйлчилгээний хөлс 0.7 сая буюу 22.9 хувь, ан амьтны нөөц ашигласны төлбөр 0.03 сая буюу 2.7 хувь, ус рашааны нөөц ашигласны төлбөр 0.9 сая буюу 46.3 хувь, байгалийн ургамал ашигласны төлбөр 0.4 сая буюу 74 хувиар тус тус тасарсан байна. Энэ нь Covid-19 цар тахалтай холбогдуулан төрөөс хогны төлбөрийг тээглэсэн, зарим жуулчны баазууд ажиллаагүй, үйл ажиллагаа эрхлээгүй удсан зэргээс тасарсан байна.

#### 3.5.11 Зардлын данс

Зардлын данстай холбоотой 36.1 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

#### Аудитын илрүүлэлт:

✚ Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас НӨАТ-ын баримтгүйгээр худалдан авалт хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг зөрчсөн байна. Тухайлбал: ЭМТ 3.5, ЗДТГ 48.8,  
 ✚ Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалыг зөрчин зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг зөрчин батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна. Тухайлбал: СӨБ, ЗДТГ, ЕБС, ИТХ, ОНХС

- ✚ Цалингийн зардлаас өглөгийн дансаар дамжуулаагүй, шууд зардлаар бүртгэсэн нь НББ-ийн холбогдох стандарт, хууль тогтоомжийг мөрдөөгүй байна. Тухайлбал: Цэцэрлэг 18.9, , ИТХ 6.6, Соёлын төв 0.2 сая төгрөг
- ✚ ЗГ болон Сангийн сайдын баталсан норм, нормативаас илүү тооцон олгосон байна. Тухайлбал: ЭМТ, ЗДТГ 1.0 сая төгрөг
- ✚ Анхан шатны баримтын бүрдэл дутуу нь НББ-ийн тухай хуулийн холбогдох заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна. ЗДТГ 5.0 сая төгрөг

### 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Бугат сумын ИТХ-ын 2020 оны орон нутгийн төсөв батлах тухай 05/01 дугаар тогтоолд зааснаар сумын ЗДТГ тайлант онд 1.5 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 1.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 113.3 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
ЗДТГ	1.50	1.70	0.2	113.3%
<b>ДҮН</b>	<b>1.50</b>	<b>1.70</b>	<b>0.2</b>	<b>113.3%</b>
ЗДТГ-ын байранд үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагуудын, халаалт, цэвэр бохир усны төлбөр, түрээс	1.50	1.70	0.2	113.3%
<b>ДҮН</b>	<b>1.50</b>	<b>1.70</b>	<b>0.2</b>	<b>113.3%</b>

### Төсвийн төлөвлөлт

Тус сумын 2020 оны төсвийг ИТХ-ын 2019 оны 07/04 дүгээр тогтоолоор орлогыг 2003.8 сая төгрөгөөр баталж ИТХ-ын 2020 оны 09 дүгээр сарын 30-ний 05/01 тоот тогтоолоор 1945.8 буюу 58.0 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Тодотголоор оны эхний үлдэгдлээс санхүүжих дүнг 12.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, санхүүгийн дэмжлэгийг 8.2, ОНХС-гийн орлогын шилжүүлгийг 0.1, тусгай зориулалтын шилжүүлгийг 18.4, соёлын төвийн санхүүжилтийг 1.1, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын байр ашиглалттай холбоотой зардлын санхүүжилтийг 32.1 сая төгрөгөөр тус тус бууруулсан байна.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 7 хөтөлбөрт зориулан 1945.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1863.1 сая төгрөгийг урсгал зардалд, 82.7 сая төгрөгийг эргэж төлөгдөх зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 972.0 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 722.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 56.1 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 21.0 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 80.8 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл

ажиллагааны орлогоос, урьд оны үлдэгдлээс 93.4 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 892.7 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 738.1 сая төгрөг орон нутгийн төсвөөс, 48.6 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас, 18.6 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 62.6 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос, урьд оны үлдэгдэл 77.5 сая нийт 1760.7 сая төгрөгийн санхүүжилт буюу 185.2 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосон байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 62.6 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 18.6 сая төгрөгөөр тасарсан нь СХС-гийн орлого 38.4 хувиар зээлийн эргэн төлөлт дутуу хийгдсэнээс шалтгаалжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1707.5 сая төгрөг буюу 87.8 хувьтай байгаа нь өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин ажилласан, урсгал үйл ажиллагааны зардалд тэвчиж болох зардлыг санхүүжүүлээгүйгээс шалтгаалсан байна. Үүнд:

- ✚ Урсгал үйл ажиллагааны зардалд тэвчиж болох зардлыг хойшлуулсан,
- ✚ Боловсролын байгууллагын хоол хүнс, үдийн цай, дотуур байрны зардал хэмнэгдсэн,

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 17.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын 4 төсөл, арга хэмжээнд 56.1 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 25.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 1.9 сая, Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 33.1 сая, дээд шатны төсвийн захирагчаас 23.5 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 0.1 сая, нийт 58.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс Цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 2.2, хангамж бараа материалд 1.6, нормативд зардалд 17.2, Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид 2.6, Бараа үйлчилгээний бусад зардалд 28.9, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 0.2, биет ба биет бус хөрөнгө худалдан авахад 4.6 сая төгрөгийг тус тус зарцуулж, орон нутгийн төсөвт 1.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

### **3.7 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 156 мэдээллээс 100 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийн хугацаа болоогүй, 50 мэдээллийг хугацаа хоцроож, 4 мэдээлэл мэдээлээгүй, 54.7 сая төгрөгийн мэдээллийг байршуулаагүй мөн төсвийн шууд захирагчид нэгдсэн системд нийт 32 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Тухайлбал: Төсвийн төвлөрүүлэн захирагч нь ОНХС-гийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг мэдээлээгүй, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлт, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбар, тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлт, төсвийн төсөл зэрэг ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжсэн 25.8 сая төгрөгийн 4 арга хэмжээ, СХС-гийн 0.1 сая төгрөгийн зээл, Баг хөгжүүлэх

сангийн 4.7 сая төгрөгийн 5 зээл, БХС-гийн 24.1 сая төгрөгийн захирамжийг мэдээлээгүй байна.

### 3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 3 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		/сая төгрөг/ Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт							
Албан шаардлага							
Зөвлөмж	3	-	3	-	-	-	100
Нийт	3	-	3	-	-	-	100

### 3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 1 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 2 тусгай сан нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 3 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 тусгай сан 4 байгууллага түүвэрт хамрагдсан, БХС, баг хөгжүүлэх сангууд нэгтгэсэн санхүүгийн тайланд хамрагдсан байна. Тус сангууд нь тусгай сан болон байгууллагын алинд ч хамаардаггүйгээс төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгдсэн санхүүгийн тайлангийн аудитад хамрууллаа.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд ЕБС “Зөрчилгүй”, ЗДТГ,ЭМТ, СӨБ “Сөрөг” дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 146.9 сая төгрөгийн алдаа, 1 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 146.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмжийг хүргүүллээ.

#### Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүгүй нэгтгэсэн байна.

#### Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь хугацаа хоцроосон 50, огт мэдээлээгүй 4 мэдээлэл, хэтрэл хэмнэлтийн шалтгаан тайлбар, тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлт, төсвийн төсөл зэрэг ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжсэн 4 арга хэмжээний 25.8 сая, СХС-гийн 0.1 сая төгрөг, Баг хөгжүүлэх сангийн 4.7 сая төгрөгийн 5 зээл, БХС-гийн 24.1 сая төгрөгийн захирамжийг байршуулаагүй байна. Мөн харьяа байгууллагууд нэгдсэн системд мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мөн харьяа байгууллагууд нэгдсэн системд мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3.1, 3.2, 4.1-д заасныг зөрчсөн, тохиолдсон байх, хэрэгжилт, үнэн зөв байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлэх

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 89.4 сая төгрөгийн алдаа, зөрчил 4.1 сая төгрөгийн 6 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 65.3 сая төгрөгийн 10 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 20.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 11 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

### **3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Төсвийн Ерөнхийлөн захирагч төсвийн жилийн дундуур хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд тухайн жилийн төсөвтөө оруулсан өөрчлөлт, хийсэн зохицуулалтынхаа гүйцэтгэлийг нь анхны батлагдсан зорилт, хүрэх үр дүнтэй харьцуулж тайлагнадаг байх, Харин төсвийн Төвлөрүүлэн захирагч харьяа байгууллагуудынхаа худалдах, худалдан авах гэрээний хэрэгжилтийг цаг хугацаанд нь дүгнэх асуудлыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## **4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### **4.1 БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ.**

4.1.1 Илрүүлэлт: Тайлант онд нийт 11.7 сая төгрөгийн өглөг, 17.5 сая төгрөгийн авлага нэмэгдсэн, 2011-2018 оны насжилттай СХС-гийн 93.2 сая, ЖДҮДС-гийн 10.3 сая, ЭМТ-ийн 8.8 сая төгрөгийн авлага нь Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4.2 дахь заалтыг хэрэгжүүлэн өр, авлага үүсгэхгүй байх шаардлагыг биелүүлээгүй байна.

4.1.2 Эрсдэл: өр, авлагын насжилт нэмэгдэж, эзэнгүй болох.

4.1.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэн өмнөх оны өр, авлагыг барагдуулах, СХС-гаас олгосон зээлийн хугацаа хэтэрсэн зээлдэгчийн асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн, авлагыг бүрэн барагдуулж, төсвийг хохиролгүй болгож, зээлийн гэрээний заалтыг нарийвчлан сангийн журамтай уялдуулан шинэчлэх.

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрч хэрэгжүүлж ажиллах, албан тоот ирүүлсэн.

### **4.2 Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал**

4.2.1 Илрүүлэлт: Тайлант хугацаанд төлөвлөгдөөгүй газрын 1.1 сая төгрөгийн орлого төвлөрсөн, төлөвлөгдсөн орлогын 10 нэр төрлийн орлого давсан нь хувиараа мод бэлтгэн борлуулдаг иргэдтэй татварын тооцоо хийсэн, “Эрдэнэс таван толгой” ХК-ийн хувьцаанаас, хадгаламж нэмэгдсэн, урьд оны бууны албан татварыг төлсөн, Орхон аймагт улсын чанартай авто зам баригдаж Бугат сумын нутгаас хайрга шинээр олборлосон, төлөвлөсөн модны метр куб-ээс давуулж олгосон, мөн төлбөрийн хувь хэмжээ өссөн зэргээс хамаарч орлого давсан байна. Хэдийгээр орлого нийт дүнгээр давсан ч нэр төрлөөр авч үзвэл хог хаягдлын үйлчилгээний хөлс 0.7 сая буюу 22.9 хувь, ан амьтны нөөц ашигласны төлбөр 0.03 сая буюу 2.7 хувь, ус рашааны нөөц ашигласны төлбөр 0.9 сая буюу 46.3 хувь, байгалийн ургамал ашигласны төлбөр 0.4 сая буюу 74 хувиар тус тус тасарсан байна. Энэ нь Covid-19 цар тахалтай холбогдуулан төрөөс хогны төлбөрийг тэглэсэн, зарим жуулчны баазууд ажиллаагүй, үйл ажиллагаа эрхлээгүй удсан зэргээс тасарсан байна.

4.2.2 Эрсдэл: Бодиттой төлөвлөөгүйгээс орлого давах тасарснаас гүйцэтгэлд их хэмжээний өөрчлөлт орох, оновчтой бус зарцуулалт хийгдэх

4.2.3 Өгсөн зөвлөмж: Төсөв боловсруулахдаа цаг үе, орчин нөхцөл буюу тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөж батлуулах.

4.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Бугат сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

#### 4.3 Хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

4.3.1 Илрүүлэлт: Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас НӨАТ-ын баримтгүйгээр худалдан авалт хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 347 тушаалыг хэрэгжүүлж ажиллаагүй нь эрх ба үүрэг, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.3.2 Эрсдэл: Орлогыг нуун дарагдуулах, тайлагнахгүй байх

4.3.3 Өгсөн зөвлөмж: НӨАТ тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, 17.3.2, 17.6 заалтуудыг мөрдөж, анхан шатны баримтыг И баримтаар бүрэн баталгаажуулж хэвших.

4.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

#### 4.4 Дотоод хяналттай холбоотой асуудал.

4.4.1 Илрүүлэлт: Аудитаар нийт 89.4 сая төгрөгийн 27 алдаа, зөрчил илэрсэн нь үнэлгээ, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.4.2 Эрсдэл: Төсвийн хөрөнгийг зүй зохисгүй, үр ашиггүй зарцуулагдах.

4.4.3 Өгсөн зөвлөмж: Санхүүгийн дотоод хяналтыг сайжруулах, төсвийн сахилга баттай ажиллах.

4.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэн ажиллах, албан тоот ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2021 оны 9 дүгээр сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАН ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР



Д.АНХБАЯР  
Ж.ЭНХЦООДОЛ

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

АУДИТОР



А.СУВДАА